

БАТЛАВ.

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-
ИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



Ж.ГАНБАТ

БАТЛАВ.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Р. СЭДДОРЖ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

2023 оны 04. сарын 14. өдөр

№ 97/2023/190

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2.5, 60.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн нэг талаас Өмнөговь аймаг (цаашид “Аймгийн удирдлага” гэх), түүнийг төлөөлж Өмнөговь аймгийн Уул уурхай, байгаль орчин, дэд бүтцийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч Н.Энхбат, негээ талаас Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой нүүрсний ордын MV-011943, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956, MV-016881, MV-016882, MV-016883 дугаартай нийт 8 тусгай зөвшөөрөлтэй 68,471 га талбай бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” ХК (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх), түүнийг төлөөлж Захиргаа удирдлагын газрын дарга Н.Анун нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой нүүрсний уурхайгаас нүүрс олборлох, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаатай холбоотой уул уурхайн цогц төсөл хэрэгжүүлэхдээ төлөвлөлтийн үе шатнаас эхлэн уурхайг ашиглахтай холбогдсон дэд бүтцийг бүтээн байгуулах, байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн онцлог, хөгжлийн бодлоготой уялдуулан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж ирснийг талууд тэмдэглэн, энэхүү гэрээ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 179 дугаар тогтооолоор батлагдсан загвар гэрээний хүрээнд боловсруулагдсан энэ гэрээгээр Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дээр дурдсан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон талуудын эрх, үүрэг, хамтын ажиллагааг зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ талууд эрх бүхий байгууллагаас баталсан Тавантолгойн ордыг цогцоор нь хөгжүүлэх урт хугацааны стратегийн хөтөлбөр, бизнес төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгон орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий хамтын ажиллагааг дэмжин ажиллана.



1.3. Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 /гурав/ жилийн хугацаанд буюу 2023-2026 оныг дуустал хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.4. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМУУД

1.4.1. Талууд гэрээг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, харилцан бие биенээ дэмжих, төсөл болон гэрээтэй холбоотой аливаа асуудлаар хоорондоо ил тод, нээлттэй байдлыг ханган ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

1.4.2. Өмнөговь аймаг болон нөлөөллийн сумдын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор талууд хүлээсэн үүргээ биелүүлэх, түүнд хяналт тавих, тулгамдаж байгаа асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай зүйлсийн талаар нэгдсэн ойлголтыг бий болгон хамтран ажиллана.

1.4.3. Талууд энэхүү гэрээгээр уурхайн ашиглалт, үйлдвэрлэлтэй холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байрыг нэмэгдүүлэх болон орон нутгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг харилцан уялдаатай хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор гэрээний хугацаанд хамтран хэрэгжүүлэх ажлын төрөл, хугацааны талаар харилцан зөвшилцөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр баталж хэрэгжүүлнэ.

1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс батлагдсан төсвийн хүрээнд Өмнөговь аймгийн боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, орон нутгийн хөгжил, жижиг дунд бизнесийн үйл ажиллагаа болон салбарын бүтээн байгуулалтыг дэмжих санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийг дэмжих санд байршуулна.

1.6. 2023 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн нийт үнийн дүн 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг байхаар талууд харилцан тохиролцсон. Энэ санхүүжилтэд Хамтын ажиллагааны хорооны баталсан төсөл, төлөвлөгөө, Өмнөговь аймгаас ирүүлсэн бүтээн байгуулалтын ажил, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардал, энэ гэрээний дагуу талуудын хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зардал, НӨАТ, бусад татвар, хураамж болон холбогдох бүх зардал багтсан болно.

1.7. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх ажлын талаар орон нутгийн иргэдийн хэлэлцүүлгийг Хамтын ажиллагааны хорооны хурлаас өмнө талууд хамтран зохион байгуулж, иргэдийн оролцоог хангаж ажиллана.

1.8. Талуудын төлөөллөөс бүрдсэн Хамтын ажиллагааны хороог жил бүрийн 10 сарын эхний 10 хоногт багтаан хуралдуулж дараа оны төсвийн саналыг эрэмбэлэн гаргахаас гадна хамтын ажиллагааны хороог жилд 3-с доoshgүй удаа хуралдуулна.

1.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд батлагдсан төсвөөс илүү гарсан зардлыг санхүүжүүлэхгүй, хандив өгөхгүй.

1.10. Аймгийн удирдлага нь гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар мэдээлэл, тайлбарыг улирал бүр Тусгай зөвшөөрөл эзэмшигчид ирүүлнэ.

1.11 Талуудын хамтын ажиллагааны хүрээнд "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", "Хот, хөдөөгийн сэргээлт", "Хүнс хангамж, аюулгүй байдлын хөдөлгөөн /Хүнсний хувьсгал/" зэрэг Монгол улсын Засгийн газраас авч

хэрэгжүүлж буй томоохон ажлуудыг Орон нутгийн хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлэх байдлаар талууд хамтран хэрэгжүүлнэ.

1.12 Энэ гэрээний 1.11-т тусгасан үндэсний хөтөлбөр, хөдөлгөөний хүрээнд хийх ажлыг Талууд харилцан тохирч, Хамтын ажиллагааны хороо хамтын ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлнэ.

ХОЁР. АЙМГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангана.
- 2.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бодлого, төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол мэдээлэл өгч, саналыг нь авна.
- 2.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож хэрэгжүүлэхээр тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцнө.
- 2.4. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайг Газрын тухай хуулийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-д эзэмшигчтэй зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцнө;
- 2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан аливаа хүсэлт, шаардлагыг хуулиар олгогдсон эрхийн хүрээнд хурдан шуурхай шийдвэрлэнэ.
- 2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах газар, авто зам, цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх, усан хангамж, дэд бүтцийн барилга байгууламж барих зориулалтаар газар ашиглах зөвшөөрөл авах эрхтэй бөгөөд аймгийн удирдлага нь хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйлдвэрлэлд ашиглах техникийн ус ашиглах зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авах бөгөөд аймгийн удирдлага нь холбогдох зөвшөөрлийг олгоно.
- 2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн үйл ажиллагаа болон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотойгоор аймгийн удирдлага, төр, захиргааны байгууллагаас тодорхой асуудлаар дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 2.9. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ажилтнууд болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллана.
- 2.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.
- 2.11. Хүүхэд хамгаалах чиглэлээр хамтран ажиллах;

2.12. Хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг;

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон төлөвлөгөөний дагуу үйлдвэр, уурхайн орчин, замын маршрутын дагуу хөрс, ургамал, булаг, шанд гол, горхи, газрын гүний ус, ан амьтан хамгаалах ажлыг зохион байгуулна.
- 3.2. Аймгийн удирдлага, төр, захиргааны байгууллагаас шаардлагатай зөвшөөрөл авах, төслийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой асуудлаар дэмжлэг туслалцаа авна.
- 3.3. Энэхүү гэрээний хүрээнд хийгдсэн ажлуудыг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтэд хагас, бүтэн жилээр мэдээлнэ.
- 3.4. Компанийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу аймгийн удирдлага, Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлнэ.
- 3.5. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжийг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгож болно.
- 3.6. Орон нутагт уул уурхайн бус үйлдвэрлэлийг дэмжиж, нэмүү өртөг шингэсэн бараа, ажил, үйлчилгээ эрхэлдэг орон нутгийн хуулийн этгээдийг дэмжих бодлого баримтална.
- 3.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн түүх, ёс заншлыг хүндэтгэж соёлын өвийг хадгалах, түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах, уламжлалт мал аж ахуй,.govийн бус нутгийн аялал жуулчлалыг дэмжихэд аймгийн удирдлагатай хамтран ажиллана.
- 3.8. Орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, үзлэг оношлогоо, шинжилгээнд хамрагдах, эмчилгээ сувилгаа хийлгэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.9. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, шаардагдах техник, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилчид болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллана.
- 3.10. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон бусад орон нутгийн төрийн байгууллагын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах чиглэлээр хамтран ажиллана.
- 3.11. Хүүхэд хамгаалах, тэдний сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах, авьяас чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.



- 3.12. Өмнөговь аймгийн өвлийн хэрэгцээний нүүрсний тодорхой хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр нийлүүлэх асуудлыг аймгийн удирдлагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.
- 3.13. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, гамшгийн үед болон түүний улмаас учирсан хохирлыг арилгах хүрээнд орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлнэ.
- 3.14. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төсөлд хамаарах газрыг тогтоон, хамгаалалтад авч тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж, аливаа аюултай газрыг хашиж хамгаалах, тусгаарлах арга хэмжээ авна.
- 3.15. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан болон төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг нутгийн захиргааны байгууллага, иргэдэд жил бүр мэдээлнэ.
- 3.16. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллана.
- 3.17. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагт байнга ашигладаг тээврийн хэрэгслийг Өмнөговь аймгийн Авто тээврийн газарт бүртгүүлж, жил бүрийн үзлэгт хамруулж холбогдох татварыг төлнэ.
- 3.18. Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд тусгай зөвшөөрлийн талбай байрлах газрыг давуу эрхтэйгээр эзэмшинэ.

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

4.1. Орон нутагт иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр

- 4.1.1. Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан, тухайн үеийн зах зээлийн үнээр санал болгож байгаа тохиолдолд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжиж, гэрээлэн ажиллана.
- 4.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт ажилтнуудын 30 хүртэлх хувьд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах арга хэмжээ авна.
- 4.1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгаас ажилтнуудыг сонгон шалгаруулалтаар авах тохиолдолд Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй иргэдээс бүрдүүлж болно.
- 4.1.4. Өмнөговь аймгийн оюутнуудад олгох сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлэх, эзэмшиж байгаа мэргэжлийг нь харгалzan уурхай дээр үйлдвэрлэлийн дадлага хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

- 4.1.5. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулна.
- 4.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Өмнөговь аймагт байрлах их дээд сургууль, коллежтэй хамтран ажиллах, техник технологи, геологи, уул уурхайн инженер, техникийн нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ

4.2. Дэд бүтцийн чиглэлээр

- 4.2.1. Шинэ суурьшлын бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөгөөний дагуу хийх бүтээн байгуулалтын ажлуудыг аймаг орон нутаг болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цогцэций сумын Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.
- 4.2.3. Шинэ суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулахад зарцуулагдах хөрөнгийн хамтран шийдвэрлэнэ.
- 4.2.4. Тавантолгой бүлэг ордын уул уурхай, хүнд үйлдвэр, дэд бүтцийн төслүүдийн усны хэрэгцээг гадаргын усаар хангах хүртэлх хугацаанд эхний ээлжид гүний усны ордыг ашиглах, цаашдаа Говийн бүс нутгийг гадаргын усаар хангах бодлого баримтална.
- 4.2.5. Компанийн бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх төслийн хүрээнд хийгдэх барилга угсралт, дэд бүтэц бүтээн байгуулалтын ажилд орон нутгийн аж ахуйн нэгжийг дэмжин оролцуулах бодлого баримтална.

4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр.

- 4.3.1. Орон нутгийн эдийн засгийн хөгжил, бизнесийг дэмжих бодлого хэрэгжүүлж зохих дэмжлэг үзүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх байдлаар уул уурхайгаас хараат бус хөгжлийг бий болгоно.
- 4.3.2. Төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, аливаа төсөл хэрэгжүүлэхдээ нутгийн иргэдийн санал, хүсэлтийг харгалzan үзнэ.
- 4.3.3. Талууд уламжлалт мал аж ахуй болон бэлчээр ашиглах, хадгалан хамгаалах, фермер, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, усжуулах ажилд хамтран ажиллана.
- 4.3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч уламжлалт өв соёл, түүх, зан заншлыг хадгалах, хамгаалах, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрийг дэмжин, хамтран ажиллана.



4.4. Тусгай зөвшөөрөл бүхий талбайд түүх соёлын дурсгалт зүйлс, нутгийн иргэдийн өвөлжөө, хаваржааг хамгаалах чиглэлээр

- 4.4.1. Компани нь лицензийн талбайд орших эртний булш, бунхан, түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, шилжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.4.2. Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчинд нутагладаг малчин иргэдийн малын бэлчээр, ундны болон ахуйн хэрэглээний усаа хэрэглэхэд, талбайн шав тэмдгийн хүрээнээс гадуур ямар нэг хориг хязгаар тавихгүй байх, нутгийн иргэдийн зорчих зам талбайг хөндөж, хаахгүй байх, зөвхөн тодорхойлогдсон маршрутын дагуу зассан замаар явна.

4.5. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр.

- 4.5.1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлсэн газрын давхардлыг арилгана.
- 4.5.2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд зөвшөөрөлгүйгээр иргэн, аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулсан бол газрыг чөлөөлөх арга хэмжээг авна.
- 4.5.3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд цаашид газар өмчлүүлж, эзэмшүүлэхгүйгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад газар ашиглуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцөнө.

4.6. Байгаль орчныг хамгаалах талуудын эрх, үүрэг

- 4.6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар Ашигт малтмалын тухай хуульд заасан үүргийг биелүүлэн ажиллана.
- 4.6.2. Уурхайн хөрсний бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, үйл ажиллагааны нөлөөллөөр эвдэгдсэн хөрс, газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглахуйц хэвийн байдалд оруулж нөхөн сэргээх арга хэмжээг авна.
- 4.6.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн олборлолт явуулах зорилгоор ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмал, гадаргын болон гүний усны төлбөрийг тухайн үед мөрдөгдөж байгаа хууль, эрх бүхий байгууллагаас баталсан тарифын хэмжээгээр тооцож, орон нутгийн тесөвт төлөх ба ус ашиглах нөхцөл нь бусад ус ашиглагчтай адил байна.



4.6.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн хөгжлийн бодлогод туссан “Усжуулалтын II аян” хөтөлбөрийн хүрээнд бус нутагт уул уурхайн нөлөөллийн сумдад 2-с доошгүй гүний худаг байгуулна.

4.6.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан Цогтцэций суманд мод тарьж, арчилалт, хамгаалалтыг 3 жилийн хугацаанд хийж амьдрах чадвартай болгож орон нутагт хүлээлгэн өгнө.

4.6.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тоосжилт, орчны бохирдоос сэргийлэх арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлнэ.

4.7. Нөлөөллийн бус дэх иргэд болон Сумын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах чиглэлээр

4.7.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн иргэдийг шинэ суурьшлын бус руу нүүлгэн шилжүүлэх ажлыг аймгийн удирдлага болон тус бус нутагт үйл ажиллагаа эрхэлж буй бусад аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулах, тус багийн иргэдэд хөрөнгийн үнэлгээгээр тогтоогдсон нөхөн олговрыг олгоно.

4.7.2. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газарт аюул осол гарсан тохиолдолд нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага харьяалал харгалзахгүйгээр тээврийн хэрэгсэл, материал тоног төхөөрөмж, эмийн зүйл олгох, холбооны хэрэгслээр үйлчлэх, аюул ослын үр дагаврыг арилгахад шаардагдах бусад дэмжлэг үзүүлнэ,

4.7.3. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, нас барагтыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр төсөл арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх, дэмжиж ажиллана.

ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

- 5.1 Энэхүү гэрээг байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор “Хамтын ажиллагааны хороо” /цаашид “Хороо” гэх/-г аймгийн захиргаа, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг оролцуулан байгуулж ажиллуулна.
- 5.2 Хороо нь энэ гэрээний хүрээнд хэрэгжүүлэх тухайн жилийн ажлын төлөвлөгөө баталж, гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хэлэлцэж, санал, зөвлөмжийг Талуудад хүргүүлнэ.
- 5.3 Хороо нь талуудын тэгш оролцоог хангахуйц нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хорооны гишүүдээр аймгийн удирдлагыг төлөөлж 3, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж 3 гишүүнийг нэр дэвшиүүлэх бөгөөд хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнэ.
- 5.4 Хамтын ажиллагааны хорооны даргыг хорооны анхны хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар томилно.

- 5.5 Хорооны нэг гишүүн саналын нэг эрхтэй байх бөгөөд Хороо нь шийдвэрээ гишүүдийн дийлэнх олонхийн саналаар буюу Хорооны 5 буюу түүнээс дээш гишүүд дэмжсэнээр гаргана.
- 5.6 Хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд хурлын дэгийг Хорооны хурлаар батална.
- 5.7 Хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх зорилгоор Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн төлөөлөгчийг Даланзадгад суманд ажиллуулна.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

- 6.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор гэрээ байгуулсан талаар орон нутгийн иргэдэд мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 5 хоногийн дотор байршуулна.
- 6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээ байгуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор гэрээ байгуулсан талаар Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.
- 6.3 Гэрээний хувийг ажлын 10 хоногийн дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.
- 6.4 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны эхний улиралд багтаан аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.
- 6.5 Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 7.1 Талууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөрчсөн талд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.
- 7.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрөөс хамаарах болон үл хамаарах аливаа нөхцөл байдал, учир шалтгаан, хүчин зүйлийн улмаас уурхайн үйл ажиллагаа түр болон урт хугацаанд зогсох, хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээ хэлцэлд заасан хязгаарлалтын хүрээнд тухайн зардлыг гаргаж чадахгүй болох буюу гаргахыг хориглосон, хязгаарласан нөхцөл байдал үүсвэл талууд харилцан зөвшилцэж Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дангаар гаргах шийдвэрээр санхүүжилтийг зогсоох эсхүл хэмжээг бууруулж (түр, тодорхой бус хугацаагаар эсхүл бүр мөсөн) болно. Энэ бүхэн нь Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хариуцлага тооцох буюу үүргээ зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

**ХЭЭР
№01**

- 8.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдоо Монгол Улсын шүүхэд гаргаж болно.

ЕС. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 9.1 Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
- 9.3 Байгалийн гамшиг, гоц халдварт өвчний улмаас тогтоосон хэл хорио, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдал, төр засгин шийдвэр, зах зээлийн нөхцөл байдал хүндэрсэн гэх мэт давагдашгүй хүчин зүйлс нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд талуудын үүргийн биелэлтийг хойшлуулах болон гэрээг цуцалж болно.
- 9.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрөл дуусгавар болсон эсхүл цуцлагдсан тохиолдолд энэхүү Гэрээг хугацаанаас өмнө цуцалсанд тооцно.
- 9.5 Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэх бөгөөд Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2 хувь Өмнөговь аймгийн захиргаа 1 хувийг тус бүр хадгална.
- 9.6 Энэ гэрээг байгуулснаар талуудын хооронд 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан ЭТТ-2021/407 дугаартай Хамтын ажиллагааны гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨЛӨӨЛЖ:
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УУЛ УУРХАЙ,
БАЙГАЛЬ ОРЧИН, ДЭД БҮТЦИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГИ

Н.ЭНХБАТ

Хаяг: Өмнөговь аймаг Даланзадгад
сум Нутгийн удирдлагын ордон
Утас: 7053-3620
Факс:(976) 7053-3604

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ЖК-ИЙН
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА



Н.АНУН

Хаяг: “Эрдэнэс Тавантолгой” ЖК Финанс
төв, Жигжиджав-8 Чингэлтэй дүүрэг, 1-р
хороо Улаанбаатар хот-15160

Утас: 7505-5555
Факс: 70119595